



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГААНУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/160/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 70003775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Албан шаардлага	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/297
танай _____-ны № _____-т

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0224 Auditin 2 Gazar-13.Docx

001050188

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,398,740.35	5,293,702.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,940.00	4,940.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,940.00	4,940.00
3121	Төгрөг	4,940.00	4,940.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,940.00	4,940.00
33	АВЛАГА	379,534.53	379,534.91
335	Бусад авлага	379,534.53	379,534.91
3351	Байгууллагаас авах авлага	2.24	2.62
3352	Хувь хүмүүсээс авах авлага	379,532.29	379,532.29
34	УРЬДЧИЛГАА	1,196,970.81	1,812,970.81
34600	Урьдчилж гарсан зардал	1,196,970.81	1,812,970.81
35	БАРАА МАТЕРИАЛ	2,817,295.01	3,096,257.00
354	Хангамжийн материал	2,817,295.01	3,096,257.00
35410	Бичиг хэргийн материал	1,469,369.01	999,860.00
35470	Бусад хангамжийн материал	1,347,926.00	2,096,397.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	766,801,674.68	729,263,998.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	766,801,674.68	729,263,998.28
392	Биет хөрөнгө	761,716,424.5	724,708,648.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	834,893,774.80	834,893,774.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,459,592.16)	(141,689,388.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,000,000.00)	(15,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,504,616.50	49,527,066.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,328,999.98)	(20,928,298.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,963,772.66	5,873,822.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,099,147.23)	(3,210,328.75)
39217	Ном	242,000.00	242,000.00
393	Биет бус хөрөнгө	5,085,250.09	4,555,350.13
39301	Программ хангамж	5,398,000.00	5,992,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,078,949.91)	(3,202,849.87)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,766,200.00	1,766,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	771,200,415.03	734,557,701.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	771,200,415.03	734,557,701.00
51	Засгийн газрын хувь оролцоо	72,629,683.00	72,629,683.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,629,683.00	72,629,683.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	72,629,683.00	72,629,683.00
512	Хуримтлагдсан үр дүн	596,517,697.51	559,874,983.48
51210	Өмнөх үеийн үр дүн	648,108,554.32	596,517,697.51
51220	Тайлант үеийн үр дүн	(51,590,856.81)	(36,642,714.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,053,034.52	102,053,034.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	771,200,415.03	734,557,701.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	352,161,200.00	368,823,900.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,040,000.00	22,603,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,040,000.00	22,603,100.00
120006	Түрээсийн орлого	5,040,000.00	6,480,000.00
120005	Бусад орлого	-	1,042,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		15,081,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	347,121,200.00	346,220,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	347,121,200.00	346,220,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,121,200.00	346,220,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	403,752,056.81	405,466,614.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,752,056.81	405,466,614.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,442,547.93	334,140,390.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,815,257.42	199,238,121.96
210101	Үндсэн цалин	151,305,863.06	142,574,435.14
210102	Нэмэгдэл	45,155,894.36	41,887,586.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,353,500.00	14,776,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,884,407.39	25,910,362.24
210201	Тэтгэврийн даатгал	18,281,396.7	17,952,194.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,752.70	1,989,891.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,720,601.98	1,591,913.32
210204	Ажилгүйдлийн даатгал	430,150.72	396,578.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,301,505.21	3,979,783.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,709,535.44	32,280,505.00
210301	Гэрэл, цахилгаан	913,125.44	1,010,675.00
210302	Түлш, халаалт	198,000.00	1,122,000.00
210303	Цэвэр, бохир ус		428,400.00
210304	Байрны түрээс	29,598,410.00	29,719,430.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,215,436.14	7,556,880.99
210401	Бичиг хэрэг	2,782,442.00	2,671,309.01
210402	Тээвэр, шатахуун	3,667,660.00	2,414,729.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,740,036.14	2,470,842.98
210408	Бараа материал акталсны зардал	3,025,298.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210604	Урсгал засвар		
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,641,255.00	13,061,744.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,717,755.00	10,290,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,500.00	203,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	312,400.00	220,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,176,656.54	56,092,776.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,176,656.54	56,092,776.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,309,508.88	71,326,223.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,482,579.00	13,485,176.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,113,579.00	13,189,976.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	369,000.00	295,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,826,929.88	57,841,047.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,826,929.88	57,841,047.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(51,590,856.81)	(36,642,714.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(51,590,856.81)	(36,642,714.03)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	648,108,554.32	822,791,271.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	648,108,554.32	822,791,271.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(51,590,856.81)	(51,590,856.81)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	596,517,697.51	771,200,415.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	596,517,697.51	771,200,415.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(36,642,714.03)	(36,642,714.03)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,629,683.00	102,053,034.52	559,874,983.48	734,557,701.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>352,161,200.00</u>	<u>353,742,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,040,000.00	7,522,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,040,000.00	7,522,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,040,000.00	7,522,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,040,000.00	6,480,000.00
120009	Бусад орлого	-	1,042,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	347,121,200.00	346,220,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	347,121,200.00	346,220,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,121,200.00	346,220,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>352,161,200.00</u>	<u>353,742,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,161,200.00	353,742,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,851,691.12	282,416,576.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,765,230.81	199,238,122.34
210101	Үндсэн цалин	162,201,045.80	159,421,158.43
210102	Нэмэгдэл	38,242,085.01	25,040,863.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,322,100.00	14,776,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,884,406.49	25,910,362.24
210201	Тэтгэврийн даатгал	18,287,949.53	17,952,194.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,149,063.25	1,989,891.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,719,409.78	1,591,913.32
210204	Ажилгүйдлийн даатгал	429,653.44	396,578.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,298,330.49	3,979,783.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,501,535.44	32,058,505.00
210301	Гэрэл, цахилгаан	913,125.44	1,010,675.00
210302	Түлш, халаалт	990,000.00	900,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	428,400.00
210304	Байрны түрээс	29,598,410.00	29,719,430.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,867,263.38	8,673,842.98
210401	Бичиг хэрэг	2,542,600.00	2,161,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,029,600.00	3,425,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,295,063.38	3,086,842.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,598,000.00	2,880,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,598,000.00	2,880,000.00
210604	Урсгал засвар	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,235,255.00	13,655,744.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,717,755.00	10,290,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,500.00	203,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	906,400.00	814,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,309,508.88	71,326,223.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,482,579.00	13,485,176.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,113,579.00	13,189,976.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	369,000.00	295,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,826,929.88	57,841,047.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,826,929.88	57,841,047.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,940.00	4,940.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,940.00	4,940.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	346,720,800.00	295,901,752.56	50,819,147.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,720,900.00	295,901,752.56	50,819,147.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,594,100.00	282,416,576.56	36,177,523.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,772,400.00	199,238,122.34	30,534,377.66
210101	Үндсэн цалин	180,099,200.00	159,421,158.43	20,678,141.57
210102	Нэмэгдэл	36,865,400.00	25,040,863.91	11,824,536.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,807,800.00	14,776,100.00	(1,968,300.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,019,200.00	25,910,362.24	5,108,837.76
210201	Тэтгэврийн даатгал	21,828,400.00	17,952,194.85	3,876,205.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,297,700.00	1,989,891.85	307,808.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,200.00	1,591,913.32	246,286.68
210204	Ажилгүйдлийн даатгал	459,500.00	396,578.52	62,921.48
210205	Эрүүл мэндийн даатгал	4,595,400.00	3,979,783.70	615,616.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,327,300.00	32,058,505.00	268,795.00
210301	Гэрэл, цахилгаа	1,125,200.00	1,010,675.00	114,525.00
210302	Түлш, халаалт	900,000.00	900,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	429,000.00	428,400.00	600.00

210304	Байрны түрээс	29,873,100.00	29,719,430.00	153,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,791,200.00	8,673,842.98	117,357.02
210401	Бичиг хэрэг	2,161,800.00	2,161,800.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,425,200.00	3,425,200.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,204,200.00	3,086,842.98	117,357.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,880,000.00	2,880,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,880,000.00	2,880,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,803,900.00	13,655,744.00	148,156.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,290,300.00	10,290,000.00	300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	348,600.00	348,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	203,144.00	84,856.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	-	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	817,000.00	814,000.00	3,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,126,800.00	13,485,176.00	14,641,624.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,126,800.00	13,485,176.00	14,641,624.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,831,600.00	13,189,976.00	14,641,624.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	295,200.00	295,200.00	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	346,720,800.00	295,901,752.56	50,819,047.44
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	346,220,800.00	288,379,752.56	57,841,047.44
131001	Улсын төсвөөс санхүүжих	346,220,800.00	288,379,752.56	57,841,047.44
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	7,522,000.00	(7,022,000.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	6,480,000.00	(5,980,000.00)
120009	Бусад орлого	-	1,042,000.00	(1,042,000.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,940.00	(4,940.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,940.00	(4,940.00)
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ			
65	Ажиллагсдын тоо	18	17	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	12	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 14-ний хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Б.Үжин нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг менежер Г.Ганцэцэг хэрэгжүүлсэн.

Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Их хурлын 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 58 дугаар тогтоолоор “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулагдсан байна.

Цагааннуур чөлөөт худалдааны бүс байгуулах зорилго нь бүсэд үзүүлэх хөнгөлөлтүүдэд тулгуурлан гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оруулж олон улсын худалдаа, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалын үйл ажиллагааг хөгжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг багасгаж улс орны хөгжилд тодорхой түлхэц үзүүлэх юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 346,720.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,467.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,642.7 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4.9	4.9	-
Авлага	379.5	379.5	-
Урьдчилж гарсан зардал	1,197.0	1,813.0	616.0
Бараа материал	2,817.3	3,096.3	279.0
Үндсэн хөрөнгө	766,801.7	729,264.0	(37,537.7)
Нийт хөрөнгө	771,200.4	734,557.7	(36,642.7)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,629.7	72,629.7	-
Хуримтлагдсан үр дүн	596,517.7	559,875.0	(36,642.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,053.0	102,053.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	771,200.4	734,557.7	(36,642.7)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 729,264.0 мянган төгрөг болж 37,537.7 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 35 дугаар тогтоолоор анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 30,028.6 мянган төгрөгийг данснаас хасан, 15,081.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, ашиглах хугацааг 2-5 жилээр сунгасан ба шинээр 2,880.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.
- Мөн ТӨБЗГ-ын 448 дугаар тогтоолоор анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 38,000.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг автомашиныг дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрлийг олгосон ба дуудлага худалдаагаар 23,000.0 мянган төгрөгийн Тоёота Прадо маркийн автомашин худалдан борлуулж данснаас хассан, хуримтлагдсан элэгдэл 53,028.6 мянган төгрөгөөр буурч, тайлант оны элэгдлийн зардалд 56,092.8 мянган төгрөгийг бүртгэсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347,621.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс урсгал зардлыг 1,400.4 мянган төгрөгөөр бууруулан 346,720.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 346,720.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 346,220.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 346,220.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7,522.0 мянган төгрөг нийт 353,742.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 295,901.7 мянган төгрөгийг зарцуулж, 57,841.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 295,901.7 мянган төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлыг 36,177.4 мянган төгрөг, бусад урсгал зардлыг 14,641.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71201	Улсын төсвөөс санхүүжих	346,720.8	295,901.7	50,819.1	85.3
1.1	80101	Урсгал зардал	346,720.8	295,901.7	50,819.1	85.3
1.2	80626	Бараа ажил үйлчилгээний зардал	318,594.0	282,416.5	36,177.5	88.6
1.3	80802	Урсгал шилжүүлэг	28,126.8	13,485.2	14,641.6	47.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд онцгойлон анхаарах асуудалгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Цагааннуур чөлөөт бүсийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хуулийн хугацаандаа оруулсан 151 мэдээллийг мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 15,081.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад бүрэн хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,074.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 98.5 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2,074.4	1	433.9	1	1,640.5	98.5
Нийт дүн	2	2,074.4	1	433.9	1	1,640.5	98.5

ТӨБЗГ-т төвлөрүүлэх орлогыг дутуу шилжүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, худалдан авалтыг цахим төлбөрийн баримтад баталгаажуулах зөвлөмжийн зөрчлийг 1,640.5 мянган төгрөгөөр давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгонд байрлах өөрийн байрны засварыг дуусган үйл ажиллагааг явуулж байгааг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,904.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 15,081.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,822.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 2 алдаа зөрчлийн дүн 6,822.9 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 3,467.2 мянган төгрөгөөс хэтэрсэн ч аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзэн зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд 15,081.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

4.2 Албан шаардлага

1. Харилцах данснаас гарсан зарлагын гүйлгээ, цахим төлбөрийн баримтад бүртгэгдсэн анхан шатны баримтуудыг тулган шалгахад 1,640.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, нэр бүхий 2 этгээдэд шилжүүлсэн 1,582.4 мянган төгрөгийн худалдан авалтын Цахим төлбөрийн баримтад бараа, ажил үйлчилгээний нэрийг гаргасан зарцуулалтын нэрээс өөрөөр шивсэн нийт 3,222.9 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүрэн хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй, өмнөх онд хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлээгүй давтан зөрчил гаргасан.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах Албан шаардлага өгөх.

2. Засварын материалын зардалд 3,600.0 мянган төгрөгийг анхан шатны дэмжих баримтгүй, материалыг орлогоор бүртгээгүй, өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бичилт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 26.2-т "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөх, анхан шатны баримтгүй гүйлгээ бүртгэхгүй байх, Албан шаардлага өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ЦЧБ	АХГ-2022/160/НА-СТА-ТШЗ	Харилцах данснаас гарсан зарлагын гүйлгээ, цахим төлбөрийн баримтад бүртгэгдсэн анхан шатны баримтуудыг тулган шалгахад 1,640.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, нэр бүхий 2 этгээдэд шилжүүлсэн 1,582.4 мянган төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтад бараа, ажил үйлчилгээний нэрийг гаргасан зарцуулалтын нэрээс өөрөөр шивсэн нийт 3,222.9 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүрэн хангаагүй байна.	Анхан шатны баримтыг иж бүтнээр нь бүрдүүлэн бүртгэлд ажил гүйлгээг тусгах	1	3,222.9					1	3,222.9				
2	ЦЧБ	АХГ-2022/160/НА-СТА-ТШЗ	Засварын материалын зардалд 3,600.0 мянган төгрөгийг анхан шатны дэмжих баримтгүй, материалыг орлогоор бүртгээгүй, өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бичилт хийсэн байна.	НББ-ийн стандартыг дагуу бүртгэлийг хийх	1	3,600.0					1	3,600.0				
3	ЦЧБ	АХГ-2022/160/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд 15,081.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	СҮДТ, СБТ-д залруулга хийсэн.	1	15,081.1	1	15,081.1								
Дүн					3	21,904.0	1	15,081.1			2	6,822.9				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 138/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/160/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцах данснаас гарсан зарлагын гүйлгээ, цахим төлбөрийн баримтад бүртгэсэн анхан шатны баримтуудыг тулган шалгахад 1,640,500.00 төгрөгийн зарлагын гүйлгээ цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, нэр бүхий 2 этгээдэд шилжүүлсэн 1,582,400.00 төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтад бараа ажил үйлчилгээний нэрийг гаргасан зарцуулалтын нэрээс зөрүүтэй, нийт 3,222,900.00 төгрөгийн анхан шатны баримтыг бүрэн хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авч, тухай бүр хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагааннуур чөлөөт бүсийн захирагч А.Аманкелди, нягтлан бодогч М.Аманкелди нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ш.МӨНХЦЭЦЭГ

0010800472



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 136/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/160/НХ-СТБ-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагааннуур чөлөөт бүсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засварын материалын зардалд 3,600,000.00 төгрөгийг анхан шатны дэмжих баримтгүй, материалыг орлогоор бүртгээгүй, өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бичилт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 26.2 "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлд анхан шатны дэмжих баримттай гүйлгээг тусгах, аккруэл сууриар бүртгэлийг хөтлөх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагааннуур чөлөөт бүсийн захирагч А.Аманкелди, нягтлан бодогч М.Аманкелди нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Б.ҮЖИН

ТЭМДЭГЛЭЛ

Lined writing area with horizontal dotted lines.